



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/10

Хэрлэн сум

**Батлан хамгаалах хууль тогтоомжийг
сурталчлахад хөрөнгө зарцуулсугай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.2.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн иргэд, хүүхэд залуучуудад Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах зорилгоор сумдад Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах самбарыг хийж байршуулахад 1,496,000 (нэг сая дөрвөн зуун ерэн зургаан мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бэлтгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

А.ЖАРГАЛСАЙХАН

